

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР

2025 оны ... дугаар сарын ...

НИЙСЛЭЛИЙН АГААР ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН 2024-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой
тэмцэх газрын дарга



Д.Мөнхбаатар

Улаанбаатар хот,
2025 он

АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....	1-2
ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ.....	2-6
ГУРАВ. АЛСЫН ХАРАА.....	7
ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО.....	7
ТАВ. ҮНЭТ ЗҮЙЛС.....	7
ЗУРГАА. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ (SWOT).....	8-9
ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО.....	10
НАЙМ. БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ.....	10
ЕС. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	13-18

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Мандатын шинжилгээ, чиг үүрэг.....	3
Хүснэгт 2. Холбогдогч талуудын оролцоо.....	6
Хүснэгт 3. Орчны шинжилгээ.....	8
Хүснэгт 4. Стратегийн зорилго, зорилт ба хариуцах нэгж.....	11
Хүснэгт 5. Үйл ажиллагааны төлөвлөгөө	13

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

"Алсын хараа — 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2020 онд батлагдан гарснаар "Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай" хууль шинэчлэгдэн батлагдсан. Энэхүү хуулийн дагуу нийслэлийн түвшинд хөгжлийн бодлого нь дараах бүтэц, уялдаатайгаар хэрэгжинэ. Дунд хугацааны баримт бичиг - "Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", богино хугацааны баримт бичиг - "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр" багтана. Эдгээр баримт бичгүүд нь шаталсан, уялдаа холбоотой төлөвлөлтийн зарчмаар хэрэгжих бөгөөд энэ хүрээнд нийслэлийн төрийн байгууллагууд өөрсдийн эрх, чиг үүргийн дагуу стратегийн төлөвлөгөө боловсруулан баталж хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах үүрэгтэй.

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар 2006 оны 10 дугаар сард Нийслэлийн Засаг даргын 444 дүгээр захирамжаар "Агаарын чанарын алба" нэртэйгээр анх байгуулагдаж, нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах талаар гарсан хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргаас гэр хорооллыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэн Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 360 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1059 дүгээр захирамжаар Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах агентлагуудыг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан "Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар" болгон өөрчилсөн.

Энэхүү стратегийг боловсруулахад Монгол Улсын Үндсэн хууль, "Алсын хараа - 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" зэрэг бодлогын баримт бичгийг суурь үндэс болголоо.

Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт "Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна" гэж заасан болно. Мөн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам", Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал, загвар"-ыг харгалзан энэхүү стратегийг боловсруулав.

Стратеги төлөвлөгөөг боловсруулахад SMART буюу зорилго тодорхой байх (specific), хэмжиж болохуйц (measurable), зорилгодоо хүрч болохуйц байх 4 (achievable), бодитой байх (relevant), цаг хугацаатай байх (time bound efforts) гэсэн олон улсын суурь зарчмыг баримталсан болно.

Энэхүү стратеги нь Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой газрын 2025-2028 онд баримтлах бодлогын баримт бичиг юм. Стратегийг батлан хэрэгжүүлснээр ажлын үр дүн, хүртээмжийг дээшлүүлэх болно.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 350 дугаар тогтоолоор баталсан "Төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлого", Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан "Төрийн байгууллагын чиг үүрэг дахин хуваарилах аргачлал"-ын дагуу Нийслэлийн Хяналт шалгалтын газрын мандатын шинжилгээг хийлээ.

Мандат нь төрийн байгууллагын хуульд заасан чиг үүрэг болон эрх хэмжээтэй салшгүй холбоотой ойлголт юм. Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан "Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал"-д зааснаар "чиг үүрэг" гэж төрийн байгууллага хуульд заасан эрх мэдлийн хүрээнд тодорхой зорилт, үр дүнд хүрэхээр тогтвортой хэрэгжүүлж буй үйл ажиллагааны үндсэн чиглэлийг хэлнэ.

Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын мандатыг тодорхойлохдоо одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Агаарын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Хог хаягдлын тухай хууль тогтоомжийг үндэслэсэн. Дэд чиг үүргийг тодорхойлохдоо Салбарын хуулиуд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг үндэслэн тодорхойлсон байна.

Хүснэгт 1 Мандатын шинжилгээ, чиг үүрэг

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо			7
Үүнээс:	Тухайн салбарын хуулийн тоо		5
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо		31
Хуулийн зүйл, заалт	Газрын үндсэн чиг үүрэг	Газрын дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
Ерөнхий чиг үүрэг-1 Агаарын тухай хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих;			
Агаарын тухай хууль 8.1.1 Байгууллагын дотоод журам 4.1.1	Агаар, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээг нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулах	Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор агаарын чанарыг сайжруулах бүсийг тогтоож, тухайн бүсэд мөрдөх журмыг батлуулж хэрэгжилтийг хангуулах	Бодлогын хэрэгжилтийн хэлтэс
Агаарын тухай хууль 8.1.8	Улаанбаатар хотын агаар, орчны бохирдлын хэмжилт хийх, судалгаа гаргах, олон нийтийн оролцоо, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх	Агаарын бохирдлын хүний эрүүл мэнд хүрээлэн буй орчинд үзүүлэх хор уршиг, түүнийг бууруулах, угаарын хий, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэхийн тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар иргэн, хуулийн этгээдэд сургалт зохион байгуулж, зөвлөмж, сэрэмжлүүлэг хүргүүлэх	ЗСХ, БХХ, ХШХ, АЧХЗБХ Нийт хэлтэс
Ерөнхий чиг үүрэг-2 Агаар, орчны бохирдлыг бууруулж байгальд ээлтэй үр ашигтай хэрэглээг нэмэгдүүлэх замаар эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх			
Агаарын тухай хууль 8.1.6 Байгууллагын дүрэм 4.1.8	Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрхийг стандартын шаардлага хангасан шахмал түлшээр хангах	Гэр хорооллын айл, өрхийг стандартын шаардлага хангасан шахмал түлшээр хангах, түгээх, тээвэрлэх, борлуулах үйл ажиллагааг дэмжиж хяналт тавина.	Бодлогын хэрэгжилтийн хэлтэс
		Шахмал түлшний агуулахын тоог нэмэгдүүлж үйл ажиллагааг жигдрүүлэх	Бодлогын хэрэгжилтийн хэлтэс
	Нийслэлийн нутаг дэвсгэрт ажиллаж байгаа халаалтын зуухыг нэгдсэн болон хэсэгчилсэн дулаан хангамжийн системд холбох, эсвэл байгаль орчинд ээлтэй	Нийслэлийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан халаагуураар шийдэх боломжийг бүрдүүлнэ	Бодлогын хэрэгжилтийн хэлтэс
		Нийслэлийн болон төрийн өмчийн халаалтын зуухыг үе шаттайгаар буулгаж төвлөрсөн дулаан хангамжид холбох ажлыг хянах	Бодлогын хэрэгжилтийн хэлтэс

	(сэргээгдэх эрчим хүч, цахилгаан, хий, сайжруулсан түлшээр халаах г.м.) технологийн горимд шилжүүлэх;	Гэр хорооллын айл өрхийн гэр болон байшин сууцны дулаан алдагдлыг бууруулах Гэр хорооллын айл өрхүүдийг хийн халаагуурт шилжүүлэх, Алсын зайн дамжуулагчтай угаарын хий болон хий мэдрэгч төхөөрөмж худалдан авч суурилуулах	Бодлогын хэрэгжилтийн хэлтэс
Ерөнхий чиг үүрэг-3 Агаарын чанарын улсын хяналт-шинжилгээний сүлжээний нэгжийн тасралтгүй ажиллагааг хангах			
Агаарын тухай хууль 8.1.3, 17.2.1, 17.2.2	Агаар, орчны чанарын хяналт-шинжилгээний сүлжээг өргөтгөх, шилжүүлэх, өөрчлөн байршуулах талаар санал боловсруулж, төрийн захиргааны төв байгууллагад танилцуулж шийдвэрлүүлэх	Нийслэлийн агаарын чанарын хяналтын чадавхыг сайжруулж, суурин автомат харуулын тоог нэмэгдүүлж, тасралтгүй ажиллагааг хангах	Агаарын чанарын хэмжилт, зохион байгуулалтын хэлтэс
		Агаар бохирдуулагч эх үүсвэрүүд, хатуу түлшний хэмжилт хийх иж бүрэн лаборатори байгуулах	Агаарын чанарын хэмжилт, зохион байгуулалтын хэлтэс
		Агаар бохирдуулах эх үүсвэрээс ялгарах бохирдуулагч бодисыг хэмжиж стандартад нийцүүлэх	Агаарын чанарын хэмжилт, зохион байгуулалтын хэлтэс
		Агаар, орчны чанарт нөлөөлж болзошгүй үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр хэмжилт хийх	Агаарын чанарын хэмжилт, зохион байгуулалтын хэлтэс
		Хөдөлгөөнт эх үүсвэрээс үүдэлтэй агаар, орчныг бохирдуулагч бодисын агууламжийг тодорхойлох	Агаарын чанарын хэмжилт, зохион байгуулалтын хэлтэс
Ерөнхий чиг үүрэг-4 агаар бохирдуулах бодисын хаягдал, агаарт үзүүлэх физикийн сөрөг нөлөөлөл, тэдгээрийн эх үүсвэрийн тооллогыг мэргэжлийн албаны орон нутаг дахь салбартай хамтран нутаг дэвсгэртээ зохион байгуулах;			
Агаарын тухай хуулийн 8.1.5 Байгууллагын дүрэм 4.1.5	Агаар бохирдуулж байгаа эх үүсвэрийн тооллого явуулж бүртгэл мэдээллийн санг шинэчлэн бүрдүүлэх	Уурын болон 100кВт аас дээш хүчин чапалтай усан халаалтын зууханд магадлан итгэмжлэл хийж, хяналт шалгалт хийх	Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, Хяналт, шалгалтын хэлтэс
		Агаар, орчны бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн	Бодлогын хэрэгжилтийн хэлтэс

		бүртгэл тооллогыг жил бүр зохион байгуулах	
Ерөнхий чиг үүрэг-5			
Хүрээлэн буй орчинд хаягдах хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээнд хяналт тавих;			
Агаарын тухай хууль 26.1 Байгууллагын дүрэм 4.1.14	Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлж, агаар, байгаль орчны тухай хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, хэм хэмжээ, шийдвэрийн биелэлтийг хангуулах	Шахмал түлшнээс дээж авч лабораторийн шижилгээнд хамруулж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Хяналт, шалгалтын хэлтэс
		Агаар бохирдуулагч суурин болон хөдөлгөөнт эх үүсвэрүүдэд хяналт шалгалт хийх	Хяналт, шалгалтын хэлтэс

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын чиг үүргийг холбогдох хууль, тогтоомжид тулгуурлан тодорхойлсон бөгөөд тухайн чиг үүргийг захиргааны эрх хэмжээний ангиллаар авч үзсэн. Энэ хүрээнд Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан "Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал"-ыг суурь болгон үзвэл дараах байдлаар гарч ирнэ:

1. Бодлого боловсруулах: Үндэсний хэмжээний болон салбар, орон нутгийн урт, дунд, богино хугацааны стратеги зорилт боловсруулах, төлөвлөх, хууль тогтоомжийн төсөл, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, стандарт тогтоох, бодлогын хэрэгжилтийн үнэлгээ хийх чиглэлээрх эрх хэмжээ хамаарна.
2. Зохицуулалт хийх: Тодорхой үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр төрийн байгууллагаас зөвшөөрөл, лиценз, магадлан итгэмжлэх, гэрчилгээ олгох зэрэг арга хэмжээ хамаарна.
3. Зохион байгуулах: Тухайн шатны төрийн байгууллагад хуулиар тогтоож өгсөн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг удирдан чиглүүлэх эрх хэмжээ хамаарна.
4. Санхүүжилт: Тухайн шатны төрийн байгууллагад хуулиар тогтоож өгсөн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт, санхүүгийн дэмжлэг, зардал, хөрөнгө оруулалттай холбоотой эрх хэмжээ хамаарна.
5. Хүний нөөцийн бодлого: Удирдах албан тушаалтан болон албан хаагчдыг томилох, чөлөөлөх, чадавхжуулах, бэлтгэх, давтан сургах, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх зэрэг эрх хэмжээ хамаарна.
6. Хяналт, шинжилгээ, үнэлгээ: Төрийн байгууллагын дэвшүүлсэн зорилт, түүний хэрэгжилт, хүрсэн үр дүнг шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэх, ажлын чанар, гүйцэтгэлд хяналт шалгалт болон дотоод аудит хийх эрх хэмжээ хамаарна.

7. Үйлчилгээ үзүүлэх: Төрөөс үзүүлэх үйлчилгээг төрийн байгууллага болон нутгийн удирдлагын байгууллага, эсхүл гэрээний үндсэн дээр хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх эрх хэмжээ хамаарна.

Хүснэгт 2 Холбогдогч талуудын оролцоо

Сонирхогч талууд	Оролцоо					
	Мэдээлэх тайлагнах	Зөвлөх, эргэх холбоогоор хангах	Санал өгөх	Хамтран ажиллах	Шийдвэр гаргах	Бусад
Төрийн эрх барих дээд байгууллага	УИХ Засгийн газар Байгаль орчин, аялал жуулчлалын яам бусад яамдууд	✓	✓	✓	✓	
Бүх шатны шүүх, Нийслэлийн прокурорын газар		✓			✓	
Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг	✓	✓	✓	✓		
АББҮХороо	✓	✓	✓	✓	✓	✓
Нийслэлийн ЗДТГ	✓	✓	✓	✓	✓	✓
Нийслэлийн Засаг даргын дэргэдэх агентлаг, харьяа байгууллага	✓	✓	✓	✓		
Гадны төслийн байгууллагууд		✓	✓	✓	✓	
Хэвлэл мэдээллийн байгууллага		✓	✓	✓		
Олон улсын байгууллага		✓	✓	✓	✓	
Сургалт судалгааны байгууллага		✓	✓	✓	✓	
Иргэд		✓	✓	✓		
Аж ахуйн нэгж байгууллагууд		✓	✓	✓		
Төрийн бус байгууллага		✓	✓	✓		
Таван толгой түлш ХХК		✓	✓	✓		
Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ		✓	✓	✓		
Албан хаагчид		✓	✓	✓		

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Улаанбаатар хотын гэр хорооллын түлшний хэрэглээг байгальд ээлтэй шинэ дэвшилтэд технологид шилжүүлж эрүүл аюулгүй, цэвэр агаартай хот болгоно.

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Агаар, орчны бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх тогтвортой хөгжлийн зарчимд тулгуурлан шинжлэх ухаан, инноваци, олон нийтийн хамтын оролцоотой бодлогыг хэрэгжүүлж, нийслэлийн иргэд эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлнэ.

ТАВ. ҮНЭТ ЗҮЙЛС

Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар нь стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дараах зүйлсийг эрхэмлэнэ. Үүнд:

- ✓ **Ёс зүй:** Төрийн албаны ёс зүйг дээдлэн сахиж, үнэнч шударга, ил тод байдлыг эрхэмлэн ажиллана.
- ✓ **Манлайлал:** Нийслэл хотын хөгжлийн бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд идэвхи, санаачилга, хөдөлмөр, зүтгэлээр бусдыг үлгэрлэн манлайлна.
- ✓ **Хамт олон:** Албан хаагч бүрийн сурч хөгжих нөхцөлийг бүрдүүлж, нийслэл хотынхоо төлөө сэтгэл зүтгэлтэй, эрч хүчтэйгээр ажиллах сэтгэл зүйн болон ажлын таатай орчныг бий болгох байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.
- ✓ **Хариуцлага:** Хариуцсан ажлынхаа чанар, гүйцэтгэлийг төлөвлөсөн хугацаанд нь, зорилтот түвшинд нь хүргэхийн төлөө оюун ухаан, хүч хөдөлмөрөө дайчлан ажиллана.
- ✓ **Ур чадвар:** Орчин үеийн техник, технологи, ололтот туршлагыг эзэмшиж үнэ цэнээ нэмэгдүүлэн төрийн албан хаагч болон хувь хүний хувьд тасралтгүй хөгжинө.
- ✓ **Ил тод нээлттэй байх:** Хуулиар нууцын зэрэглэлд хамаарахаас бусад мэдээлэл нь олон нийтэд нээлттэй, ил тод, ойлгомжтой байх
- ✓ **Шударга байх:** Нийтийн эрх ашгийг эрхэмлэх, адил тэгш боломжоор хангах
- ✓ **Хууль дээдэлдэг байх:** Үйл ажиллагаандаа хуулийг сахин биелүүлэх, хэрэглэх, хуульд нийцсэн шийдвэр гаргах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх
- ✓ **Хүнд сурталгүй байх:** Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх
- ✓ **Түргэн шуурхай байх:** Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх

ЗУРГАА. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ (SWOT)

Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар өмнө тулгамдсан асуудал, цаашид хүрэхээр зорьж байгаа зорилго, зорилт түүнийг хэрэгжүүлэх стратегийг тодорхойлохын тулд SWOT болон PESTLE шинжилгээг дотоод болон гадаад хүчин зүйлийн хүрээнд хийлээ.

Стратегийг боловсруулахын тулд хуулийн хүрээнд тодорхойлогдсон чиг үүргээ хэрэгжүүлэх чадавхын өнөөгийн давуу, сул тал, орчны нөлөөллийн боломж, эрсдэлийг илэрхийлэх гол хүчин зүйлсийг тус тус сонгож авсан болно. Стратегийн зорилтыг тодорхойлохдоо тус шинжилгээний үр дүнд тулгуурлан давуу талдаа түшиглэн, сул талаа бууруул ахад чиглэсэн арга замыг сонгож, гадаад орчны боломжийг ашиглаж, эрсдэлийг бууруулах зарчмыг баримталсан.

Хүснэгт 3. Орчны шинжилгээ

ДОТООД ОРЧИН	
Давуу тал	Сул тал
1. Байгууллагын эрхэм зорилго, алсын хараа тодорхойлсон 2. Эрхэм зорилгоор үйл ажиллагааны зарчим, чиг үүрэг тодорхойлсон 3. Хэлтэс тус бүрээр чиг үүрэг тодорхойлогдсон 4. Агаарын бохирдлыг бууруулахад засгийн газар болон нийслэлийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байдаг. 5. Бодлого, зорилго зорилт, тодорхой хэрэгжүүлдэг, тайлагнадаг 6. Агаарын чанарыг бууруулахад чиглэсэн суурь судалгаа, материалын нөөцтэй 7. ОУ-ын хамтын ажиллагааны "ЖАЙКА" байгууллагын шугамаар чадавхжуулсан туршлагатай 6 мэргэжилтэнтэй 8. Магадлан итгэмжлэгдсэн лабораторитой, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн орчин үеийн хэмжилтийн багаж тоног төхөөрөмжөөр хангагдсан. 9. Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр хангагдсан	1. Алсын хараа, эрхэм зорилго чиглэлийг албан хаагчдад тайлбарлан ойлгуулах, хоногшуулж суулгаагүй 2. Ажлын ачаалал их, гэнэтийн яаралтай ажлууд 3. Ажлын байр хол, түгжрэлтэй, байрны агааржуулалт муу 4. Ур чадвар нэмэгдүүлэх, мэргэшүүлэх сургалтын төлбөрийг шийддэг байх 5. Амралтын өрөө хангалтгүй 6. Илүү цагаар суух, хөдөлгөөний хомсдол, ажлын стрессээс үүдэлтэй эрүүл мэндийн асуудлууд 7. Гадаад дотоодод хурал, семинар сургалтуудад оролцох, туршлага судлах боломж дутмаг 8. Хүний нөөц дутагдалтай 9. Ажилчдын мэдлэг чадварыг сайн ашигладаггүй 10. Нийгмийн баталгаа ялангуяа орон байраар хангагдах, хөнгөлөлтэй зээлд хамрагдах боломж байдаггүй 11. Суурь судалгаа болон материалын нөөцийг бодлого


	тодорхойлох, хэрэгжүүлэх арга хэмжээнд тусгагддаггүй 12. Стандартыг нийт албан хаагчдад нутагшуулах ажил хангалтгүй 13. Байгууллагын үндсэн чиг үүргийг цаашид гүйцэтгэхэд бүтэц орон тооны хувьд албан хаагчдын тоо бага 14. Хэмжилтийн лабораториуд түрээсийн байр ашигладаг тул хэмжилтийн ажилд сул тал болдог 15. Дотоод аудит, хяналтын нэгж байхгүй, эрсдэл тодорхойлох, түүнийг даван туулах туршлагагүй 16. олон мэргэжилтэн солигдох, жирэмслэх нь төрийн байгууллагын мэргэших, чадавх, мэдээллийн бааз суурь үүсэх, мониторинг хийх боломж, нөхцөлийг хангахгүй байх нөхцөл үүссэн
ГАДААД ОРЧИН	
Боломж	Эрсдэл
1. Улсын төсвөөс нийслэлд олгох санхүүжилт, хөрөнгө оруулалт сайн 2. Байгууллагын нэр хүнд өсөх боломжтой. 3. Үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдэх 4. Хамтын ажиллагаагаа өргөжүүлэх 5. Шинэ төрлийн төлбөрт үйлчилгээ нэмэгдэх 6. Олон улсын байгууллагууд агаарын бохирдлыг бууруулахад анхаарал хандуулж, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх 7. Агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн хууль эрх зүй, бодлогын бичиг баримт тусгаж батлуулах	1. Улс төрийн нөлөөллөөс шалтгаалж байгууллагын удирдлага байнга солигдох 2. 3. Нийгмийн цахим сүлжээ хараа хяналтгүй, ташаа, худал мэдээлэл тархсанаас үүдэн гарах эрсдэл их 4. Иргэдийн худалдан авах чадвар буурснаар байгальд ээлтэй дэвшилтэд технологийн хэрэглээ багасна 5. Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн тасрахгүй байгаа нь агаарын бохирдлыг нэмэгдүүлэх томоохон хүчин зүйлс болж байна. 6. Төсөв санхүү багатайгаас шинэ техник, технологи нэвтрүүлэх боломж хязгаарлагдмал

ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Улаанбаатар хотын агаар бохирдуулагч эх үүсвэрийг дэвшилтэд технологид суурилсан шийдлээр үе шаттайгаар бууруулж, иргэдийг тав тухтай орчинд амьдрах нөхцөлийг төр, хувийн хэвшил, иргэдийн хамтын оролцоотойгоор бүрдүүлэх нь энэхүү стратегийн гол зорилго болно.

1. Байгальд ээлтэй дэвшилтэд техник технологи нэвтрүүлэх замаар агаар бохирдуулах эх үүсвэрүүдээс ялгарах бохирдлыг бууруулах
2. Агаар бохирдуулах эх үүсвэр болон орчны агаарын чанарыг тодорхойлох, хяналт мониторингийн менежментийг сайжруулах
3. Агаарын бохирдлыг бууруулахад иргэд, олон нийтийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, эрүүл амьдрах зөв дадлыг төлөвшүүлнэ.
4. Байгууллагын чиг үүрэгтэй холбоотой гарсан тогтоол шийдвэрийн биелэлтийг хангуулж, тайлагнах, дотоод үйл ажиллагааны хяналт шалгалт, үйл ажиллагааг сайжруулна.
5. Тогтвортой хөгжилт тулгуурласан засаглалын шинэчлэлийн бодлогын хэрэгжүүлнэ.

НАЙМ. БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ



СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА БҮТЦИЙН УЯЛДАА

Хүснэгт 4. Стратегийн зорилго, зорилт ба хариуцах нэгж

Д/д	Стратегийн зорилго	Стратегийн зорилт	Хэрэгжүүлэх байгууллага	
			Үндсэн	Хамтрагч
1	Байгальд ээлтэй дэвшилтэд техник технологи нэвтрүүлэх замаар агаар бохирдуулах эх үүсвэрүүдээс ялгарах бохирдлыг бууруулах	1.1.Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрхийг стандартын шаардлага хангасан шахмал түлшээр хангах	НАОБТГ	НЗДТГ, УБЗАА, ДЗДТГ, "ТТГ" ХХК
		1.2.Нийслэлийн болон төрийн өмчийн халаалтын зуухыг үе шаттайгаар буулгаж, төвлөрсөн дулаан хангамжид холбох ажлыг хянах	НАОБТГ	НЗДТГ, УБЗАА, ДЗДТГ
		1.3.Нийслэлийн гэр хорооллын айл өрхийг дэвшилтэд технологи бүхий шөнийн дулаан хуримтлуурт цахилгаан болон хийн халаагуураар шийдэх боломжийг бүрдүүлнэ	НАОБТГ	НЗДТГ, ДЗДТГ, "ТТГ" ХХК
		1.4 Гэр хорооллын айл өрхийн гэр болон байшин сууцны дулаан алдагдлыг бууруулах	НАОБТГ	НЗДТГ, ДЗДТГ, "ТТГ" ХХК
		1.5 Алсын зайн дамжуулагчтай угаарын хий болон хий мэдрэгч төхөөрөмж суурилуулах	НАОБТГ	НЗДТГ, ДЗДТГ, ТХУТ ОНӨААТҮГ
2	Агаар бохирдуулах эх үүсвэр болон орчны агаарын чанарыг тодорхойлох, хяналт мониторингийн менежментийг сайжруулах	2.1. Нийслэлийн агаарын чанарын хяналтын чадавхыг сайжруулж, суурин автомат харуулын тоог нэмэгдүүлж, тасралтгүй ажиллагааг хангана	НАОБТГ	НЗДТГ, УБЗАА, ДЗДТГ
		2.2. Агаар бохирдуулагч эх үүсвэрээс ялгарч байгаа бодисын хэмжээг тодорхойлно.	НАОБТГ	НЗДТГ, ЦУОШГ
		2.3. Агаар бохирдуулагч эх үүсвэрүүд, хатуу түлшний хэмжилт хийх иж бүрэн лаборатори байгуулна.	НАОБТГ	НЗДТГ
		2.4. Уурын болон 100кВт аас дээш хүчин чадалтай усан халаалтын зууханд магадлан итгэмжлэл хийж хяналт тавих	НАОБТГ	НЗДТГ, ДЗДТГ
		2.5. Хөдөлгөөнт эх үүсвэрээс үүдэлтэй агаар, орчныг бохирдуулагч бодисын агууламжийг тодорхойлох	НАОБТГ	АТҮТ, ТЦА

		2.6. Дуу чимээ, үнэрийн бохирдлын судалгаа хэмжилтийг хийх	НАОБТГ	НЗДТГ, НОБГ, ЭЦА
		2.7. Шахмал түлшнээс дээж авч лабораторийн шинжилгээнд хамруулж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	НАОБТГ	АМГТГ
3	Агаарын бохирдлыг бууруулахад иргэд, олон нийтийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, эрүүл амьдрах зөв дадлыг төлөвшүүлнэ.	3.1. Агаар, орчны бохирдлыг бууруулах талаар төсөл арга хэмжээг хэрэгжүүлэн зохион байгуулах	НАОБТГ	НЗДТГ, УБЗАА, ДЗДТГ
		3.2. Агаарын бохирдлын хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх хор уршиг, түүнийг бууруулах, угаарын хий, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэхийн тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар иргэн, хуулийн этгээдэд сургалт зохион байгуулж, зөвлөмж, сэрэмжлүүлэг хүргүүлнэ.	НАОБТГ	НЗДТГ, УБЗАА, ДЗДТГ
4	Байгууллагын чиг үүрэгтэй холбоотой гарсан тогтоол шийдвэрийн биелэлтийг хангуулж, тайлагнах, дотоод үйл ажиллагааны хяналт шалгалт, үйл ажиллагааг сайжруулна.	4.1. Байгууллагын стратегийн болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх	НАОБТГ	НЗДТГ
		4.2. Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэх, хууль эрх зүйн асуудлыг хянан судлах, тэдгээрийг зохицуулах санал зөвлөмж гаргах, зөрчил, маргааныг зохицуулах, албан хэрэг хөтлөлтийг хууль тогтоомжийн дагуу хөтлөн явуулах, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг зохион байгуулж, газрын хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх	НАОБТГ	НЗДТГ
5	Тогтвортой хөгжилт тулгуурласан засаглалын шинэчлэлийн бодлогын хэрэгжүүлнэ	5.1.Зорилго, алсын хараа, стратегийг сайжруулна	НАОБТГ	НЗДТ
		5.2.Байгууллагын соёл ба манлайлалыг хөгжүүлнэ	НАОБТГ	НЗДТ
		5.3.Оролцогч талуудын оролцоо хангана.	НАОБТГ	НЗДТ
		5.4.Тогтвортой үнэ цэнийг бий болгоно	НАОБТГ	НЗДТ
		5.5.Гүйцэтгэл ба өөрчлөлтийг удирдагыг сайжруулна.	НАОБТГ	НЗДТ
		5.6.Оролцогч талуудын сэтгэл ханамж, ойлголт	НАОБТГ	НЗДТ
		5.7.Стратегийн болон үйл ажиллагааны гүйцэтгэл	НАОБТГ	НЗДТ

ЕС. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 5.

Бодлогын баримт тусгагдсан болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Бичигт болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги	Шалгуур үзүүлэлт	Суурь он	Суурь түвшин	Зорилто д он	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр
Стратегийн зорилго 1.								
Байгальд ээлтэй дэвшилтэд техник технологи нэвтрүүлэх замаар агаар бохирдуулах эх үүсвэрүүдээс ялгарах бохирдлыг бууруулах								
1.1 Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрхийг стандартын шаардлага хангасан шахмал түлшээр хангах	Шахмал түлшийг түгээх, тээвэрлэх, борлуулах	Тээвэрлэсэн түлшний хэмжээ, тонн	2025	541000 тн	2026	887000 тн	Батлагдсан төсөв	
1.2 Гэр хорооллын айл өрхийг бүх хийн болон цахилгаан халаагуурт шилжүүлэх	Бүх төрлийн хийн болон цахилгаан халаагуурт шилжүүлэх	Хийн болон цахилгаан халаагуурт шилжүүлсэн өрх	2024	-	2028	170855	Батлагдсан төсөв	
1.3 Гэр хорооллын айл өрхийн гэр болон байшин сууцны дулаан алдагдлыг бууруулах	Айл өрхүүдийг дулаалах	Дулаалсан өрх	2024	-	2028	170855	Батлагдсан төсөв	
1.4 Алсын зайн дамжуулагчтай угаарын хий мэдрэгч төхөөрөмж худалдан авч суурилуулах	Угаарын хий мэдрэгчийг суурилуулах	Суурилуулсан төхөөрөмж	2024	112000	2028	170855	Батлагдсан төсөв	
Стратегийн зорилго 2.								
Агаар бохирдуулах эх үүсвэр болон орчны агаарын чанарыг тодорхойлох, хяналт мониторингийн менежментийг сайжруулах								
2.1. Нийслэлийн агаарын чанарын хяналтын чадавхыг сайжруулж, суурин автомат харуулын тоог нэмэгдүүлж, тасралтгүй ажиллагааг хангана	Суурин автомат харуулын үйл ажиллагааг хангах	Суурин харуулын тоо	2024	6	2028	7	Батлагдсан төсөв	
2.2. Агаар бохирдуулагч эх үүсвэрээс ялгарч байгаа бодисын хэмжээг тодорхойлно.	Агаарын чанарын үзүүлэлтийг тооцох	Агаар бохирдуулагч бодисын агууламж	2024	63/101	2028	37,5/50	Батлагдсан төсөв	

2.3. Агаар бохирдуулагч эх үүсвэрүүд, хатуу түлшний хэмжилт хийх иж бүрэн лаборатори байгуулна.	Хэмжилт хийж хяналт тавих	Байгуулсан лаборатори тоо	2024	0	2028	1	Батлагдсан төсөв
2.4. Уурын болон 100кВт аас дээш хүчин чадалтай усан халаалтын зууханд магадлан итгэмжлэл хийж хяналт хийх	Магадлан итгэмжлэл хийж хяналт тавих	Магадлан итгэмжлэл хийсэн тоо	2024	50	2028	160	Батлагдсан төсөв
2.5. Агаарын бохирдлын хөдөлгөөнт эх үүсвэрээс агаарт гаргах бохирдуулах бодисын хаягдлын стандарт, хэмжилт хийх	Стандартад нийцүүлэх	Хэмжилт хийсэн тээврийн хэрэгслийн тоо	2024	450	2028	2000	Батлагдсан төсөв
2.6. Дуу чимээ, үнэрийн бохирдлын судалгаа хэмжилтийг хийх	Стандартад нийцүүлэх	Хэмжилт хийсэн тоо	2024	-	2028	100	Батлагдсан төсөв
2.7. Шахмал түлшнээс дээж авч лабораторийн шинжилгээнд хамруулж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Стандартад нийцүүлэх	Дээжийн тоо	2024	20	2028	100	Батлагдсан төсөв
Стратегийн зорилго 3.							
Агаарын бохирдлыг бууруулахад иргэд, олон нийтийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, эрүүл амьдрах зөв дөдлэг төлөвшүүлнэ.							
3.1. Агаар, орчны бохирдлыг бууруулах талаар төсөл арга хэмжээг хэрэгжүүлэн зохион байгуулах	Хамтын ажиллагааг хангах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2024	2	2028	10	Батлагдсан төсөв
3.2. Агаарын бохирдлын хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх хор уршиг, түүнийг бууруулах, угаарын хий, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэхийн тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар иргэн, хуулийн этгээдэд сургалт зохион байгуулж, зөвлөмж, сэрэмжлүүлэг хүргүүлнэ.	Олон нийтийг мэдээллээр хангаж оролцоог нэмэгдүүлэх	Зохион байгуулсан сургалтын тоо Сэтгэл ханамжийн судалгаа	2024	5	2028	20	Батлагдсан төсөв
Стратегийн зорилго 4.							

Байгууллагын чиг үүрэгтэй холбоотой гарсан тогтоол шийдвэрийн биелэлтийг хангуулж, тайлагнах, дотоод үйл ажиллагааны хяналт шалгалт, үйл ажиллагааг сайжруулна							
4.1. Байгууллагын стратегийн болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх	Төлөвлөгөө боловсруулах	Гүйцэтгэлийн хувь	2024	80%	2028	100%	Батлагдсан төсөв
4.2. Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэх, хууль эрх зүйн асуудлыг хянан судлах, тэдгээрийг зохицуулах санал зөвлөмж гаргах, зөрчил, маргааныг зохицуулах, албан хэрэг хөтлөлтийг хууль тогтоомжийн дагуу хөтлөн явуулах, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг зохион байгуулж, газрын хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх	Хяналт шинжилгээ хийх, санал дүгнэлт гаргах	Хэрэгжилтийн хувь	2024	100%	2028	100%	Батлагдсан төсөв
Стратегийн зорилго 5. Тогтвортой хөгжилт тулгуурласан засаглалын шинэчлэлийн бодлогын хэрэгжүүлнэ							
5.1. Зорилго, алсын хараа, стратегийг сайжруулна	-Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалтыг "Алсын хараа-2050" болон нийслэлийн хөтөлбөртэй уялдуулан сайжруулах	Хэрэгжилтийн хувь	2024	0	2028	100	
	-Стратегийн зохион байгуулалт,	Хэрэгжилтийн хувь	2024	0	2028	100	

	бүтээмжийг нэмэгдүүлэх								
5.2.Байгууллагын соёл манлайлалыг хөгжүүлнэ ба	-Манлайлал, хамтын ажиллагаа, ёс зүйн сургалт зохион байгуулах -Дотоо харилцаа мэдээлэл солилцоог сайжруулах -Байгууллагын үнэт зүйлсийг өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх үнэлгээ хийж санал авах	Хэрэгжилтийн хувь	2024	0	2028	100			
5.3.Оролцогч талуудын оролцоо хангана.	-Талуудыг шийдвэр гаргалт, төлөвлөлтөд идэвхитэй оролцуулах -Санал гомдол, зөвлөмж хүлээн авах, оролцоог нэмэгдүүлэх сургалт семинарь зохион байгуулах -ил тод мэдээлэл тайланг нийтэд танилцуулах	Хэрэгжилтийн хувь	2024	0	2028	100			

5.4.Тогтвортой үнэ цэнийг бий болгоно	-Үйл ажиллагаа, төсөл, үйлчилгээний үр ашиг чанарыг дээшлүүлж нийгэм эдийн засгийн тогтвортой байдлыг хангах -Оролцогч талуудын хамтын ажиллагааг дэмжих	Хэрэгжилтийн хувь	2024	0	2028	100	
5.5.Гүйцэтгэл ба өөрчлөлтийг удирдагыг сайжруулна.	-Төсөл үйл ажиллагааны гүйцэтгэлийг тогтмол үнэлэх, тайлагнах -Өөрчлөлт шинэчлэлийг удирдах процессыг стандартчилах -Мэргэжлийн сургалт чадавхийг сайжруулах	Хэрэгжилтийн хувь	2024	0	2028	100	
5.6.Оролцогч талуудын сэтгэл ханамж, ойлголт	-Стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг хянах -Гүйцэтгэлийн үзүүлэлт (KPI)-ийг тогтоож, тогтмол үнэлгээ хийх -Дүн шинжилгээ хийж санал зөвлөмж гаргах	Хэрэгжилтийн хувь	2024	0	2028	100	

	-Сургалтаар чадавхийг бэхжүүлэх								
5.7.Стратегийн ажиллагааны гүйцэтгэл	болон үйл	-Стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг хянах -Гүйцэтгэлийн үзүүлэлт (KPI)-ийг тогтоож, тогтмол үнэлгээ хийх -Дүн шинжилгээ хийж санал зөвлөмж гаргах -Сургалтаар чадавхийг бэхжүүлэх	2. Хагас, бүтэн жилээр тайлан танилцуулсан тоо	2024	0	2028	100		